

**“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-т 2026 оны 1 дүгээр улиралд  
ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан**

2026.03.30

“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ нь иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхдээ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль”, Засгийн газрын 2005 оны 67, 2018 оны 258 дугаар тогтоолыг мөрдлөг болгон иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчлэх зарчим баримтлан ажиллаж байна.

**Нэг. “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын хэмжээнд шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын талаар.**

2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл нийт 140 өргөдөл, гомдол ирсэн байна. Үүнээс: байгууллагын албан хаагчдаас 62 өргөдөл, хүсэлт, байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой 6 өргөдөл ирсэн нь нийт өргөдөл, гомдлын 48.6 хувийг эзэлж байна.

Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/66 дугаар тушаалаар баталсан “Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам”-ын дагуу 72 иргэний өргөдөл, гомдол (*нийт өргөдөл, гомдлын 51.4 хувь*)-ын шийдвэрлэлтийн тайланг дээрх журмын 5.4.1-д заасан хугацаагаар тасалбар болгон энэхүү тайланг гаргалаа.

**Хүснэгт 1. Өргөдөл, гомдлын төрөл**

| Байгууллагын нэр                | Өргөдлийн тоо (эзлэх хувь) |             |          | Гомдол      | Дүн |
|---------------------------------|----------------------------|-------------|----------|-------------|-----|
|                                 | Хүсэлт                     | Санал       | Мэдэгдэл |             |     |
| "Барилгын хөгжлийн төв"<br>ТӨҮГ | 63<br>(87.5%)              | 4<br>(5.6%) | -        | 5<br>(6.9%) | 72  |

**Хүснэгт 2. Өргөдөл, гомдол хүлээн авсан хэлбэр**

| Байгууллагын нэр                | Тоо (эзлэх хувь) |        |              |                         |               | Дүн |
|---------------------------------|------------------|--------|--------------|-------------------------|---------------|-----|
|                                 | Биечлэн          | Утсаар | Цахимаар     | 11-11 төвөөс шилжүүлсэн | Албан бичгээр |     |
| "Барилгын хөгжлийн төв"<br>ТӨҮГ | -                | -      | 8<br>(11.1%) |                         | 64<br>(88.9%) | 72  |

**Хоёр. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал.**

Тайлант хугацаанд нийт 72 өргөдөл, гомдол хүлээн авснаас Өргөдөл 67, Гомдол 5 ирсэн бөгөөд 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 60 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн бол 3 өргөдлийг ХББОСЯ руу шилжүүлж, 4 өргөдөл хуулийн хугацаандаа судлагдаж байна. Өргөдөл шийдвэрлэлт 89.6 хувьтай байна.

Мөн дээрх хугацаанд ирүүлсэн 5 гомдлыг судалж, 1 иргэнд хуулийн хугацаанд нь холбогдох хариуг мэдэгдсэн бөгөөд 4 гомдол хуулийн хугацаандаа судлагдаж байна. Гомдол шийдвэрлэлт 20 хувьтай байна.

### Хүснэгт 3. Өргөдөл шийдвэрлэлтийн байдал

| Байгууллагын нэр             | Өргөдлийн тоо | Шийдвэрлэсэн              |  |                          | Шийдвэрлэгдээгүй  |                          | Шийдвэрлэлтийн хувь |
|------------------------------|---------------|---------------------------|--|--------------------------|---|--------------------------|---------------------|
|                              |               | Иргэний талд шийдвэрлэсэн | Хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй | Тодорхой бус хариу өгсөн | Харьяаллын дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлсэн тоо | Хуулийн хугацаа болоогүй |                     |
| "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ | <b>67</b>     | 53                        | 6  | 1                        | 3   | 4                        | <b>89.6</b>         |

### Хүснэгт 4. Гомдол шийдвэрлэлтийн байдал

| Байгууллагын нэр             | Гомдлын тоо | Шийдвэрлэсэн              |  |                          | Шийдвэрлэгдээгүй  |                          | Шийдвэрлэлтийн хувь |
|------------------------------|-------------|---------------------------|--|--------------------------|---|--------------------------|---------------------|
|                              |             | Иргэний талд шийдвэрлэсэн | Хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй | Тодорхой бус хариу өгсөн | Харьяаллын дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлсэн тоо | Хуулийн хугацаа болоогүй |                     |
| "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ | <b>5</b>    | -                         | 1  | -                        | -   | 4                        | <b>20</b>           |

Ирсэн өргөдөл, гомдлыг хэлтэс, нэгжээр нь ангилбал нийт өргөдөл, гомдлын 63.8 хувь буюу 46 өргөдлийг Барилгын чанар, аюулгүй байдал, баталгаажуулалтын хэлтэс, 11.1 хувь буюу 8 өргөдөл, гомдлыг Захиргаа, аж ахуйн хэлтэс, 6.9 хувь буюу 5 өргөдөл, гомдлыг Барилга байгууламжийн зураг төслийн магадлалын хэлтэс, 5.6 хувь буюу 4 өргөдлийг Норм, нормативын хэлтэс, 4.2 хувь буюу 3 өргөдлийг Санхүү, эдийн засгийн хэлтэс, 2.8 хувь буюу 2 гомдлыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хүлээн авч судалж, шийдвэрлэсэн бол Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтэс, Барилгын материалын сорилт шинжилгээний лаборатори, Хот төлөвлөлтийн хэлтэс, Сургалт, судалгаа мэдээлэл, технологийн хэлтэс тус бүр 1 өргөдөл хүлээн авч судалж, шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд Зураг төслийн хяналтын хэлтэс, Орон сууц, нийтийн аж ахуйн хэлтэс, Мега төсөл хөтөлбөрийн нэгж, Замын-Үүд хилийн боомт дахь барилгын материалын сорилт шинжилгээний түргэвчилсэн лабораторид иргэдээс өргөдөл, гомдол ирээгүй байна.

Хүснэгт 5. Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн байдал (хэлтсээр)

| №  | Хэлтэс, нэгжийн нэр                                      | Өргөдөл, гомдлын тоо | Шийдвэрлэсэн байдал |                  |                 | Өөр байгууллага руу шилжүүлсэн | Эзлэх хувь |
|----|--|----------------------|---------------------|------------------|-----------------|--------------------------------|------------|
|    |  |                      | Хариу өгч хаасан    | Хугацаа хэтэрсэн | Хяналтад байгаа |                                |            |
| 1  | Захиргаа, аж ахуйн хэлтэс                                | 8                    | 4                   |                  | 3               | 1                              | 11.1       |
| 2  | Санхүү, эдийн засгийн хэлтэс                             | 3                    | 3                   |                  |                 |                                | 4.2        |
| 3  | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс         | 2                    | 1                   |                  | 1               |                                | 2.8        |
| 4  | Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтэс       | 1                    |                     |                  | 1               |                                | 1.4        |
| 5  | Барилга байгууламжийн зураг төслийн магадлалын хэлтэс    | 5                    | 2                   |                  | 1               | 2                              | 6.9        |
| 6  | Барилгын материалын сорилт шинжилгээний лаборатори       | 1                    | 1                   |                  |                 |                                | 1.4        |
| 7  | Барилгын чанар, аюулгүй байдал, баталгаажуулалтын хэлтэс | 46                   | 45                  |                  | 1               |                                | 63.8       |
| 8  | Норм, нормативын хэлтэс                                  | 4                    | 3                   |                  | 1               |                                | 5.6        |
| 9  | Зураг төслийн хяналтын хэлтэс                            |                      |                     |                  |                 |                                | -          |
| 10 | Орон сууц, нийтийн аж ахуйн хэлтэс                       |                      |                     |                  |                 |                                | -          |
| 11 | Хот төлөвлөлтийн хэлтэс                                  | 1                    | 1                   |                  |                 |                                | 1.4        |
| 12 | Сургалт, судалгаа мэдээлэл, технологийн хэлтэс           | 1                    | 1                   |                  |                 |                                | 1.4        |
| 13 | Мега төсөл хөтөлбөрийн нэгж                              |                      |                     |                  |                 |                                | -          |

|             |   |           |           |          |          |          |             |
|-------------|---|-----------|-----------|----------|----------|----------|-------------|
| 14          | Замын-Үүд хилийн боомт дахь барилгын материалын сорилт шинжилгээний түргэвчилсэн лаборатори |           |           |          |          |          | -           |
| <b>Нийт</b> |   | <b>72</b> | <b>61</b> | <b>0</b> | <b>8</b> | <b>3</b> | <b>100%</b> |

#### Хүснэгт 6. Өргөдөл, гомдол гаргагчид хариу мэдэгдсэн хэлбэр

| Байгууллагын нэр             | Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо | Хариу мэдэгдсэн хэлбэр (тоо, хувь) |               |             |             |
|------------------------------|-----------------------------------|------------------------------------|---------------|-------------|-------------|
|                              |                                   | Албан бичгээр                      | Цахимаар      | Утсаар      | Биечлэн     |
| "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ | <b>61</b>                         | 7<br>(11.5%)                       | 45<br>(73.7%) | 4<br>(6.6%) | 5<br>(8.2%) |

Шийдвэрлэсэн өргөдлийн 73.7% буюу 45 өргөдлийн хариуг цахимаар өгсөн нь тухайн өргөдлүүд цахим систем дэх бүртгэлээ хасуулах хүсэлтүүд тул шийдвэрлэсэн даруйд цахим системээр мэдэгдэж байгаа болно.

#### **Гурав. Гомдлыг агуулгаар ангилсан байдал.**

Тайлант хугацаанд нийт 5 гомдол ирсэн бөгөөд эдгээр өргөдлөөс 1 өргөдлийг шийдвэрлэж хариу өгсөн байна. 4 гомдлыг судалж, хуулийн хугацаанд нь хариу өгөхөөр ажиллаж байна.

“Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам”-ын гуравдугаар хавсралтаар баталсан агуулгын хүрээнд дараах байдлаар ангиллаа.

#### Хүснэгт 7. Гомдлыг агуулгаар ангилсан байдал

| №           | Гомдлын агуулга                                     | Гомдлын тоо | Эзлэх хувь  |
|-------------|---|-------------|-------------|
| 1           | Барилгатай холбогдолтой асуудлаар                   | 4           | 80%         |
| 2           | Төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой асуудлаар | 1           | 20%         |
| <b>Нийт</b> |   | <b>5</b>    | <b>100%</b> |

Гомдлын агуулгыг нарийвчлан дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 8.

| № | Иргэний Овог, нэр | Гомдлын агуулга   | Шийдвэрлэлт   |
|---|-------------------|---|---|
| 1 | Ж.Хадбаатар       | Албан хаагчийн үйлдэл (эс үйлдэхүй)-тэй холбоотой                   | Иргэнээс гаргасан гомдлын дагуу ХШҮДАХ-ээс 2025.06.02-оос хойш тус төвд хандан ирүүлсэн 11 албан бичигт дотоод хяналтыг хийж, бодит байдлыг тогтоон дүгнэлт гаргаж, танилцуулсан. |
| 2 | Дэлгэрсайхан      | Барилга байгууламжийн зураг төслийн магадлалын дүгнэлттэй холбоотой | Хугацаа болоогүй.   |
| 3 | Ц.Дондог          | Барилгын норм ба дүрэмтэй холбоотой                                 | Хугацаа болоогүй.   |
| 4 | Н.Даваасамбуу     | Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлттэй холбоотой                           | Хугацаа болоогүй.   |
| 5 | Энхцэцэг          | Шинжээч томилохтой холбоотой  | Хугацаа болоогүй.   |

Дээрх хүснэгтээс харахад хүлээн авсан нийт гомдлын дийлэнх (4) нь буюу 80% нь магадлалын дүгнэлт болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, барилгын норм, дүрэмтэй холбоотой салбарын үйл ажиллагаатай холбоотой гомдлууд эзэлж байгаа тул журмын гуравдугаар хавсралтаар баталсан агуулгын “Барилга”-ын салбар бүлэгт багтаан ангилсан болно.

**Дөрөв. Санал, дүгнэлт.**

“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-т 2026 оны 1 дүгээр улиралд нийт 140 өргөдөл, гомдол ирснээс 62 (44.3%) өргөдлийг байгууллагын албан хаагчдаас ирүүлсэн бол 6 (4.3%) өргөдөл нь байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой байсан тул “Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам”-ын 3.1.4-д заасны дагуу тайлан, мэдээнд тусгаагүй бөгөөд иргэдээс ирсэн 63 хүсэлт, 4 санал, 5 гомдлын хүрээнд тайлан, мэдээг гаргасан.

Тайлангаас харахад: иргэдээс ирсэн өргөдөл (хүсэлт, санал)-ийг хуулийн хугацаанд нь судалж, шийдвэрлэх боломжтой байна.

Харин гомдлын хувьд давтагдах шинжтэй, судалж хариу өгөхөд цаг хугацаа шаардагдахаар байна. Тухайлбал, иргэн Ж.Хадбаатарын гомдлыг судлах хүрээнд албан хаагч 11 албан бичгийг холбогдуулан судалсан байх бөгөөд хуулийн хүрээнд гомдлыг шийдвэрлэхэд судалгаа хийх, холбогдох хэлтсүүдтэй, хариуцсан албан хаагчидтай уялдаж ажиллах шаардлагатай байгаа нь ажиглагдсан.

Мөн иргэн Ц.Дондог нь тайлант хугацаанд 3 өргөдөл, гомдол (хүсэлт 1, санал 1, гомдол 1) ирүүлсэн байх бөгөөд дүн шинжилгээ хийж, давтагдсан асуудлыг бууруулах талаар холбогдох хэлтсүүдийн хариуцсан албан хаагчид уялдаж ажиллах шаардлагатай.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явц нийтдээ хэвийн боловч зарим тохиолдолд хугацаа хэтрэх, хариу тайлбар дутмаг байх асуудал үүсэж болзошгүй тул цаашид анхаарах шаардлагатай байна.

\_\_\_оОо\_\_\_